



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/436

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.4 дэх заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 474 дүгээр тогтоолын 2 дугаар заалт, Засгийн газрын 2021 оны 161 дүгээр тогтоолын 3 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “НУРБАХ” ХХК-ний хийж гүйцэтгэсэн Ерөнхий боловсролын сургуулийн урлагийн заалны барилгын засвар (Жаргалант сум)-ын ажлыг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Туулайтулга (Жаргалант сумын Засаг даргын орлогч)

Гишүүд: Д.Эрдэнэбат (Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Ц.Даваасамбуу (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

Н.Нарима (“НУРБАХ” ХХК-ний захирал)

О.Тунгалаг (Жаргалант сумын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн)

У.Саруулзаяа (Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн захирал)

Нарийн бичгийн дарга: С.Өнөржаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. “НУРБАХ” ХХК-ний хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар

8400001 1348  
Zah A/436 Ba

шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Туулайтулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ДЭЛГЭРСАЙХАН